



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар A/248

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


- “ЖАЙКА” ОУ-ын байгууллагатай хамтран зохион байгуулах “Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ, лавшруулсан тусlamж” сэдэвт сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
- Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



19

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
... өдрийн 12 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
1248



“Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ, лавшуулсан тусlamж”
сэдэвт сургалт

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд Монгол улсын эрүүл мэндийн салбарын нөхцөл байдал сайжирсаар байгаа хэдий ч орон нутаг дахь эмнэлгийн тусlamж үйлчилгээ харилцан адилгүй, өвчлөлийн бүтэц өөрчлөгдж халдварт бус өвчин, осол гэмтэл өсөх болсон. Мөн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо нь боловсронгуй болоогүй гэх мэт асуудлууд тулгарч байна.

ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага нь анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилго тавин эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Ялангуяа нэн түрүүнд сайжруулах шаардлатай байгаа яаралтай тусlamж болон холбогдох чиглэлүүдийг голчлон авч үзэхээс гадна, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах тал дээр тулхүү анхааран ажиллаж байна.

ЭМЯ, ЭМХТ, ЖАЙКА ОУ-ын байгууллагатай хамтран яаралтай тусlamжийн чиглэлээр зохион байгуулагддаг сургалтын талаар судалж, хэлэлцсэний үр дүнд амь насанд аюултай эрсдэлд орсон өвчтөний биеийн байдалд үнэлгээ өгөх, амилуулах лавшуулсан тусlamжийн арга техникийг эзэмшиүүлэх (Advanced Assessment for Life Support - AALS) сургалт зохион байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Үүнтэй холбогдуулан Япон улсад зохион байгуулагддаг AALS сургалтаас үлгэр жишээ аван сургалтын хөтөлбөр боловсруулж, нарийн ажилбар гүйцэтгэх боломжтой манекин ашиглан сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэхүү сургалт нь Монгол улсад эмнэлгийн яаралтай тусlamж үйлчилгээг сайжруулахад хувь нэмэр оруулахаас гадна, холбогдох мэргэжлийн эмч мэргэжилтэнд чиглэгдэн зохион байгуулагдах болно. Эмнэлгийн яаралтай тусlamж үйлчилгээний чадавхи сайжирснаар Монгол улсын эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний түвшинд ахиц гарна гэж үзэж байна.

Зорилго:

Амь насанд аюултай эрсдэлд орсон өвчтөний биеийн байдалд үнэлгээ хийх, амьлуулах лавшуулсан тусlamжийн арга техникийг (AALS) эзэмших

Зорилт:

- 1) AALS сургалтын талаар өрөнхий арга техник эзэмших
- 2) Яаралтай тусlamжийн үед хэрэглэдэг ABCDE үнэлгээний аргыг эзэмших
- 3) AALS-г эмнэлзүйн талбар дээр бодитоор хэрэгжүүлэх үндсэн ур чадварыг эзэмших

Богино хугацааны сургалт

*Ажлын хэсгийн гишүүд:

ЭМХТ-н ЭМАХА-н 1 мэргэжилтэн, ЖАЙКА-н төслийн 1 ажилтан

Сургалтын хугацаа: 2017 оны 12 сарын 26 өдөр

Сургалт болох газар: ЭМХТ-н хурлын заал

Эзэмших мэдлэг:

AALS-н тухай мэдлэг, яаралтай тусlamжийн анхан шатны тусlamжийн тухай мэдлэг

Эзэмших ур чадвар:

AALS-н арга техник, яаралтай тусlamжийн үед авах голлох арга хэмжээ

Эзэмших хандлага:

Яаралтай тусlamж авах шаардлагатай өвчтөнд тусlamж үзүүлэх чин сэтгэлтэй, Монгол улсын эмнэлгийн яаралтай тусlamж үйлчилгээнд хувь нэмэр оруулах хандлагыг төлөвшүүлнэ.

Сургалтын хэрэглэгдэхүүн:

Нарийн ажилбар гүйцэтгэх манекин 2 ширхэг, сэхээн амьдруулах яаралтай тусlamжийн 2 иж бүрэн хэрэгсэл, FAST-н (түргэвчилсэн эхо) хэв авиан хиймэл арьс (sonoskin) 1 ширхэг, ширээ 2, проектор, компьютер, дэлгэц.

Сургалтын арга зүй:

Нэгдсэн лекц, дадлага, багийн ажиллагаа

Сургалтын хөтөлбөр:

"Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ лавшруулсан тусlamжийн сургалт"

Ерөнхий агуулга

Амь насанд аюултай эрсдэлд орсон өвчтөний (голчлон гэмтэлд өртсөн өвтөний жишээн дээр) сценарийг ашиглан, манекин дээр дадлага гүйцэтгэн AALS-н арга техник зэмших

Сургалтын нээлт

- 1) Сургалтын өмнөх анкет (суралцагчдад урьдчилан тараана)
- 2) Сургалтын талаархи тайлбар /10 мин/
- 3) Лекц /60 мин/
- 4) Багш сценарийг хэрхэн гүйцэтгэх талаар хийж үзүүлэх /30 мин/
Зорилго: Хүрэх зорилтын талаар төсөөлөлтэй болгох
Сценари: Шахсан пневоторакс (tension pneumothorax) + аарцагны ясны хугарал (цус алдалтын шок)
- 5) Ур чадварын өртөө: /2 цаг: 60 мин * 2/
Зорилго: Эмч бүр гардан үйлдэл хийж, хэсэгчилсэн ур чадвар (partial skill) зэмшинэ.

Ур чадварын өртөө "А":

- Эзэмших чадвар: Мөгөөрсөн хоолойд гуурс тавих, амьсгалын зам чөлөөлөх мэс заслын арга
- Сценари: Ком (тархины судасны эмгэгтэй өвчтөн), амьсгалын дээд замын бөглөрөл (анафилаксид орсон өвчтөн)

Ур чадварын өртөө "Б":

- Эзэмших чадвар: Цээжний гялтангийн хөндийд гаргуур тавих (tube thoracotomy), үнхэлцэгийн хөндийд хатгалт хийх (pericardial centesis)
- Сценари: Цээжний зүүн хэсэгт бэртэл авсан өвчтөн (зүрхний тампонад, нээлттэй пневмоторакс хавсарсан)

- 6) Зохиомол үзлэг: /4 цаг: 60 мин * 4/

Зорилго: Анхан шатны тусlamжийн бүх үйл явц (whole task) –г зэмшинэ.

Сценари 1: Зав тээврийн осол. Толгой, нүүрний яс хугарсан,

амьсгалын замд дотуур цус алдалттай

Сценари 2: Мориноос унасан. Цээжин хэсгийн гэмтэлтэй, шахсан пневмоторакс (tension pneumothorax)


Сценари 3: Явган зорчигчийн осол. Аарцагны ясны хугаралтай, цус алдалтын шок

Сценари 4: Амьсгалын замын түлэгдэлт. Ком, (угаартсан)

Эхлэхийн өмнө товч тайлбар хийнэ.

Даалгавар биелүүлж дууссаны дараа, тайлан тавина.

- 7) Сургалтын дараах анкет, сэтгэл ханамжийн судалгаа /30 мин/



Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын
19 өдрийн 11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
1248

**“АМЬ ТЭНССЭН ҮЕИЙН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ, ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ”
СУРГАЛТАД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ**

1 өдрийн сургалт

№	Хэрэглэгдэх зүйлс	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бичиг хэргийн зардал	1 хүн	32	2.000	64.000
2	Гэрчилгээ	1 хүн	32	1.000	32.000
3	Цайны зардал	1 хүн/өдөр	36*2	2.000	144.000
4	Хоолны зардал	1 хүн/өдөр	36*1	8.000	288.000
6	Багшийн цагийн хөлс /магистр/	хүн *цаг	4*8	10.000	320.000
Нийт зардал					848.000

Хянасан:

Д.Гантуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Боловсруулсан: О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/